



ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272287

[И-мэйл](#)

Аудитын менежер:

Т.Майцэцэг

Утас: 70273465

СТАудитын багийн: Шинжээч

Ц.Хишигжаргал

Утас: 70273204

И-мэйл: khj_616@yahoo.com

ТӨАГ-ын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-7
• Гол шийдлүүд	8
• Залруулаагүй алдаа	8
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	8
• Аудитын санал дүгнэлт	8

ШША-ны 2013 оны Санхүүгийн тайланд ААГазар аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид ШША-ны 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байна. ШША-ны төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд ШША-ны тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

Байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн тайланд аудит хийлээ.

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг **тодруулбал:**

- Үндсэн үйл ажиллагааны орлого 3600.0 мянган төгрөгөөр батлагдсаныг гүйцэтгэлээр 5882.1 мянган төгрөг оруулж 2282.1 мянган төгрөгөөр давуулсан, урсгал зардалд 150390.2 мянган төгрөгөөр батлагдсаныг гүйцэтгэлээр 149930.7 мянган төгрөг зарцуулж 459.5 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.
- Бараа үйлчилгээний зардал нь батлагдсан төлөвлөгөөгөөр 24677.2 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 22459.9 мянган төгрөг буюу батлагдсан төлөвлөгөөнөөс 2217.3 мянган төгрөгийг хэмнэсэн байна.
- Гэрэл цахилгааны, түлш халаалт болон цэвэр бохир усны зардлуудыг гүйлгэн зарцуулах зөвшөөрөл авч автомашинд 1425.0 мянган төгрөгийн сэлбэг авч тавьсан боловч уг сэлбэг нь бараа материалын дансанд үлдэгдлээр бүртгэлтэй байна.
- Бараа материалын тодруулгын тайлангийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн орлогын дүнг мөнгөн хөрөнгийн тайлангийн зардлын дүнтэй тулгахад орлого 6243.8 мянган төгрөг байхад шилжүүлсэн мөнгө 6482.2 мянган төгрөг, зөрүү 238.4 мянган төгрөг буюу цалингаас суутгасан хандивыг журналын

бичилт буруу хийсэнийг аудитын явцад залруулав.

- Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн нийт зөрчлийн хэмжээгээр агуулгаараа урьдчилан тогтоосон материаллагын түвшингээс бага байгаа учир **зөрчилгүй санал дүгнэлт** гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан .
- Ерөнхий Аудитор 2014.02.07-ний өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ахлах нягтлан бодогч Б.Мэндсайхан болон бидэнтэй хамтран ажилласан ажилтнуудад гүнээ талархаж байна.

Аймгийн Аудитын газар

2014.02.04

Танилцуулга

1. Бид Шүүхийн шинжилгээний албаны 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байна. ШШАлбаны даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаар бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд ШШАлба нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

2. Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх

1. Аймгийн Аудитын Газар жилийн санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалтын үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

2. Дараах 8-н түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд ШШАлбаны удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Орлого, санхүүжилтийн талаар

- Шүүх шинжилгээний хүрээлэнгээс Төв Аймгийн ШША-ны 2013 оны урсгал зардлын төсвийг 150390.2 мянган төгрөгөөр төсвөөс санхүүжих, 3600.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжихээр батлагдсан байна. Тайлант оны гүйцэтгэлээр 155812.8 мянган төгрөг буюу батлагдсан төлөвлөгөөнөөс 1822.6 мянган төгрөгөөр илүү санхүүжүүлсэн байна.
- Үндсэн үйл ажиллагааны орлого 3600.0 мянган төгрөгөөр батлагдсаныг гүйцэтгэлээр 5882.1 мянган төгрөг оруулж 2282.1 мянган төгрөгөөр давуулсан, урсгал зардалд 150390.2 мянган төгрөгөөр батлагдсаныг гүйцэтгэлээр 149930.7 мянган төгрөг зарцуулж 459.5 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

2. Мөнгөн хөрөнгө

- Төлбөрт үйлчилгээний орлогыг тухай бүр байгууллагын дансанд тушаадаггүй бөөгнүүлж байж тушаадаг байна. Энэ нь төсөвийн байгууллагад мөрдөх мөнгөн кассын ажиллагааны журамд нийцэхгүй байна.
- Төрийн сангийн харилцах дансаар нийт 149930.7 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого, кассаар 5882.1 мянган төгрөгийн төлбөрт үйлчилгээний орлого нийт 155812.8 мянган төгрөгийн орлогын, 148979.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж жилийн эцэст 6833.8 мянган төгрөг үлдсэнийг онд нь багтааж төвлөрүүлсэн байна.

3. Цалингийн талаар

- Цалингийн программаас Excel файлаар хөрвүүлэн 1-12 сарын цалингийн цэсийг нэгтгэн шалгахад нийт 104950.7 мянган төгрөгийг олгохоор тооцсон байхад харилцахын гүйлгээгээр 104705.9 мянган төгрөг зарцуулж 244.8 мянган төгрөгийн зөрүүтэй. Энэ нь цалингийн программыг бүрэн ашигладаггүй, excel дээр хийж дараа нь программд шивж оруулахдаа алдаа гаргасан, арга хэмжээний суутгалыг буруу тооцоолсоноос үүссэн байна.
- Цалингийн татварын өглөгийн тооцоог тулгахад тайлангаарх татварын өглөг 1048.0 мянган төгрөг, татварын тайлангаарх өглөг 1004.0 мянган төгрөг хоорондоо 44.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Мөн НДШ-ийн тооцоог тайлангаар 69.6 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнасан байхад НДХ-тэй ямар нэгэн тооцоогүй гэж тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.
- Дээрх цалингийн зөрүү 244.8 мянган төгрөг, мөн НДХ-т өглөгөөр тооцсон 69.6 мянган төгрөг нийт 314.4 мянган төгрөгийг байгууллагын дарга нягтлан бодогч нараар хувь тэнцүүлэн төлүүлэхээр төлбөрийн акт бичив.
- Цалин болон санхүүгийн программыг бүрэн эзэмшиж, анхан шатны баримтанд тулгуурлан цаг тухай бүрд нь программаар хийж байх
- Цалингийн карт хөтөлсөн байдлыг шалгахад хүн тус бүрт карт хөтөлдөггүй, цалингийн цэсэнд гарын үсэг зуруулдаггүй байна. Нийт орон тоо 10, дарга 1, гүйцэтгэх ажилтан 9 хүний бүрэлдэхүүн ажилласан байна. 2012 оны Засгийн газрын 78-р тогтоолын дагуу албан хаагчдын цалингийн шатлал, сүлжээний дагуу цалинг зөв тогтоосон байна.

4. Бараа үйлчилгээний зардал

- Бараа үйлчилгээний зардал нь батлагдсан төлөвлөгөөгөөр 24677.2 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 22459.9 мянган төгрөг буюу батлагдсан төлөвлөгөөнөөс 2217.3 мянган төгрөгийг хэмнэсэн байна.
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар Бараа, үйлчилгээний зардал нь 29293.8 мянган төгрөгөөр тусгагдсан ба үүнд төвлөрүүлэх шилжүүлэг 6833.9 мянган төгрөгийг зардлын дүнд оруулж тусгасан байна.
- Гэрэл цахилгааны, түлш халаалт болон цэвэр бохир усны зардлуудыг гүйлгэн зарцуулах зөвшөөрөл авч автомашинд 1425.0 мянган төгрөгийн сэлбэг авч тавьсан боловч уг сэлбэг нь бараа материалын дансанд үлдэгдлээр бүртгэлтэй байна.
- Тээвэр шатахууны зардлалд 6211.8 мянган төгрөг батлагдаж 6796.1 мянган төгрөг зарцуулсан ба 584.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Шатахуунд харилцахаас 6796.1 мянган төгрөг шилжүүлж зардалд бичсэн. Тээвэр, шатахууны зардлыг тусад нь тооцдоггүй бусад хангамжийн материалд бүртгэсэн, жолоочийн тооцоо

боддоггүй, замын маршрут гаргадаггүй, зөвхөн спидометрийн заалтыг тэмдэглэж гарын үсэг зурдаг байна.

- Урсгал засварын зардалд 1828.3 мянган төгрөг батлагдсан боловч юунд зарцуулсан нь тодорхой бус, 1425.0 мянган төгрөгийн зардал гүйлгэн шилжүүлэх зөвшөөрөл авч сэлбэг хэрэгсэл авсан байна.
- Мөнгөний орлого, зарлагын журнал, ТС-гийн хуулга, ЕД, ЕЖ, өглөг авлагын дэлгэрэнгүй журнал, АШБаримтыг ашиглан шалгав. Санхүүгийн тайлангаар бараа үйлчилгээний урсгал зардал нийт дүнгээрээ хэмнэлттэй боловч зардал хооронд нь зардлын нэр төрлийг гүйлгэн зарцуулсан, ЗЭБ-5 маягтаар зөвшөөрөл авсан боловч зарцуулалтыг буруу тайлагнасан.

5. Үндсэн хөрөнгө

- Санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн эхний үлдэгдэл 27410.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 23666.4 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн үлдэгдэлтэй тулгахад тохирч байна. Тайлант онд нийт 3743.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулж зардал болгосон байна. Хөрөнгийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын бүртгэлтэй тулган шалгахад тооллого хийсэн гэх боловч бүртгэлээс өөр зүйлгүй тооцоо бодсон акт, тооллогын комиссын гарын үсэг зурж албажуулаагүй байна.
- Тус байгууллага нь 2013 онд үндсэн хөрөнгөд нэмэгдэж хасагдсан хөдөлгөөн гараагүй байна. Үндсэн хөрөнгийн тооллого хийж тооцоо бодсон байдал хангалтгүй байна.

6. Бараа материал

- Санхүүгийн байдлын тайлангаархи бараа материалын эхний болон эцсийн үлдэгдэлийн дүнг, Бараа материалын тодруулгын тайлангийн дүнтэй тулгахад тус бүр тохирч байна. Бараа материалын тодруулгын тайлангийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн орлогын дүнг мөнгөн хөрөнгийн тайлангийн зардлын дүнтэй тулгахад орлого 6243.8 мянган төгрөг байхад шилжүүлсэн мөнгө 6482.2 мянган төгрөг, зөрүү 238.4 мянган төгрөг буюу цалингаас суутгасан хандивыг журналын бичилт буруу хийсэнийг аудитын явцад залруулав.
- Бараа материалыг дансанд тусгахдаа зөв ангилан бүртгээгүй, хуулийн хугацаанд тооллого хийж, тооцоо бодсон гэх боловч үр дүн муутай болсон байна.
- Бараа материалын тайлангийн тооллого, тооцоо бодолт, анхан шатны баримтын бүрдүүлэлт зохих журмын дагуу хийддэггүй лаборант няравтай хавсран ажилладаг боловч тайлан гаргадаггүй, бараа материалын шаардах хуудсыг бүрэн бөглөдөггүй, бараа материал орлого авсан дүнгээр нь нэг дор зарлага бичиж гаргаж байна.

7. Авлага ,өглөгийн талаар

- ШШАлба нь 2013 оны эхэнд 234.6 мянган төгрөгийн авлагтай байсан ба жилийн эцсээр уг үлдэгдэл авлага барагдаагүй хэвээр байна. Мөн оны эхэнд 2395.8 мянган төгрөгийн өглөгтэй байснаас 484.1 мянган төгрөгийн өглөгийг барагдуулж жилийн эцэст 1130.8 мянган төгрөгийн өглөгтэй гэж тайлагнасан байна.
- Дээрх авлага, өглөгийг нэг бүрчлэн авч үзэхэд бусад авлага 234.6 мянган төгрөг нь тодорхой бус, ХАОАТатварын өглөг 1048.0 мянган төгрөгийн өглөгтэй гэх боловч тооцоо нийлсэн акт байхгүй, НДХэлтэст 69.6 мянган төгрөгийн өглөгтэй гэх боловч тооцоо нийлсэн акт дээр өглөг авлага байхгүй гэж баталгаажуулсан, Цалингийн өглөг -79.3 мянган төгрөг гэх боловч энэ нь уг чанартаа цалингийн авлага ба хэнд илүү олгосон нь тодорхой бус мөн урьд оны 92.5 мянган төгрөгийн өглөг хэнд өгөх нь тодорхой бус байна. Харилцагч байгууллага болон хувь хүмүүстэй хийсэн ажил гүйлгээг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.
- Тус байгууллага нь жилийн эцэст 6833.8 мянган төгрөгийн харилцах дансанд үлдэгдэл байхад өр төлбөр үүсэгсэн байна. Өр авлагыг тайланд үнэн зөв тусгаагүй байна. Иймд урд оны авлага 234.6 мянган төгрөг, цалингийн өглөг 79.3 мянган төгрөг, мөн урьд оны өглөг 92.5 мянган төгрөг нийт 406.4 мянган төгрөгийг байгууллагын дарга нягтлан бодогч нараар хувь тэнцүүлэн төлөөлэхээр төлбөрийн акт бичив.

8. Дотоод хяналт шалгалт

- МУ-ын ЗГазрын 2011.11.09 –ний өдрийн 311-р тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам батлагдсан байна. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө гэсэн заасны дагуу 2013 оны 3-р сарын 01-ны өдрийн 04 тоот байгууллагын даргын тушаал гарч дотоод хяналт шалгалтын комисс томилогдон 21-н төрлийн ажил гүйцэтгэхээр төлөвлөгөө боловсруулан батлуулсан байна. Мөн 10-р сарын 02-ны 07 тоот тушаалаар комиссын бүрэлдхүүнд өөрчлөлт оруулсан байна.
- Дотоод хяналтын комисс нь төлөвлөгөөний дагуу сар улирал бүр хяналт хийсэн тухай төлөвлөгөөний биелэлт гаргасанаас өөр дэлгэрэнгүй тайлан болон баталгаажуулсан баримтууд байхгүй байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 8 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудитын явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- ✓ Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг зөв тайлагнаж байх
- ✓ Төсвийн төлөвлөлтийг бодитой хийж зардал хооронд нь гүйлгэн зарцуулахгүй байх
- ✓ Санхүүгийн болон цалингийн программыг бүрэн эзэмшиж, тухай бүр нь гүйлгээг программаар хийж хэвших

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

Аудитын стандарт нь аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Эдгээр залруулагдаагүй алдаанууд байгууллагын удирдлагын анхаарлын төвд хүргэдэх болно. Залруулагдсан алдаа байхгүй болно

- Өглөгийн дансдын үлдэгдлийг баталгаажуулаагүй
- Хөрөнгө, бараа материалын тооцоо бодогдоогүй, тооллого чанаргүй хийгдсэн, бараа материалын тайланг үнэн зөв гаргадаггүй

Тайлбар мэдүүлгийн захидал

7. Аудитын үйл явцад аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Өмнөх зөвлөмжийн биелэлт

2012 оны санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалтай саналт дүгнэлт авсан ба ихэнх зөвлөмж хэрэгжээгүй болно.

Аудитын санал дүгнэлт

Аймгийн аудитын газраас тус тайланд **зөрчилгүй санал дүгнэлт** гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар.